

UCS 1407B:2022

## НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ




Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд  
тавих ерөнхий шаардлага



# НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд  
тавих ерөнхий шаардлага

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 23-р тогтоолоор батлав.



## ГАРЧИГ

1. Хамрах хүрээ .....	5
2. Норматив эшлэл.....	5
3. Нэр томьёо, тодорхойлолт .....	5
4. Нийтийн эзэмшлийн сандалд тавих шаардлага .....	5
5. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САНДЛЫН ТӨРӨЛ АНГИЛАЛ .....	7
6. Сандлыг байрлуулах .....	8
7. Сандлыг суурилуулах .....	9
8. САНДЛЫН МАТЕРИАЛД ТАВИХ ШААРДЛАГА .....	10
9. САНДЛЫН ӨНГӨ .....	11
10.НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САНДЛЫН ЖИШИГ ЗАГВАР .....	12
11.ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ .....	17
НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САНДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	18
13.Шалгуур үзүүлэлт .....	17
Хавсралт 1. Сандлын металл хийцлэлийн материалын төрөл, үзүүлэлт.....	19

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Сандал .....	6
Зураг 2. Нийтийн эзэмшлийн сандлын хэмжээ .....	6
Зураг 3. Түшлэгтэй сандал .....	7
Зураг 4. Түшлэггүй сандал.....	7
Зураг 5. Модон сандал.....	7
Зураг 6. Төмөр сандал .....	7
Зураг 7. Чулуун сандал .....	7
Зураг 8. Явган зам дагуу сандал байрлуулах.....	8
Зураг 9. Цэцэрлэгт хүрээлэн, амрах талбайд сандал байрлуулах загвар .....	8
Зураг 10. Цэцэрлэгт хүрээлэн, амрах талбайд сандал байрлуулах загвар .....	9
Зураг 11. Сандал суурилуулах /хөлийг газарт боож суурилуулах/ .....	9
Зураг 12. Хэсэглэл-2.....	10

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нийтийн эзэмшлийн сандлын хэмжээ .....	7
Хүснэгт 2. Сандлын суудал хийх материалын тохиромжтой байдал .....	10
Хүснэгт 3. Сандлын эдлэхүүний өнгөний төрөл .....	11
Хүснэгт 4. Сандлын ашиглалтын байдалд хяналт үнэлгээ хийх чиглэл.....	17
Хүснэгт 5. Сандлыг хүлээн авах шалгуур үзүүлэлт .....	18



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

### Г Нийтийн эзэмшилийн эд хөрөнгөд хамаарах хотын стандартыг батлах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн  $10^1$  дүгээр зүйлийн  $10^1.1$  дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийтийн эзэмшилийн эд хөрөнгө бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1402B:2022 “Нийтийн эзэмшилийн талбайд байгуулах усан оргилуурт тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг

1.2. UCS1401B:2022 “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” хотын стандарт

1.3. UCS1403B:2022 “Гадна мэдээллийн байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.4. UCS 1404B:2022 “Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.5. UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандарт

1.6. UCS1406B:2022 “Нийтийн эзэмшилийн зам талбайн хогийн саванд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.7. UCS1407B:2022 “Нийтийн эзэмшилийн зам талбайн сандалд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.8. UCS1408B:2022 “Хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбарт тавих ерөнхий шаардлага” хотын стандарт


1.9. UCS1409B:2022 “Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.10. UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1110100320

2.Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.





## НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

### UCS 1407B:2022 “НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЗАМ ТАЛБАЙН САНДАЛД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

#### 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сандал байрлуулахад дагаж мөрдөнө.

#### 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 3.01.06-90 Барилгын орчны тохижилт;
- БД 32-101-17 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт;
- MNS 6808:2019 Явган хүний зам талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага.

#### 3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

**Сандал** – гэж зам, талбай, газрын гадаргуугаас суух гадаргуу хүртэлх босоо хэмжээ;

**Суудлын өндөр** – гэж сандлын суух гадаргуугийн ирмэгээс түшлэг хүртэлх хэмжээ;

**Суудлын үр ашигт гүн** – гэж суух гадаргуугийн урд дээд ирмэгийг дугуйруулсан хэсэг;

**Архитектурын хориглох хийц** – гэж нийтийн эзэмшлийн талбайн суухад тохиромжгүй, хориглосон, аюултай газруудад байрлуулсан хориглох үүрэгтэй хийц.


#### 4. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САНДАЛД ТАВИХ ШААРДЛАГА

- 4.1. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулсан сандал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:



Зураг 1. Сандал (Жишээ зураг)

- 4.1.1. Төлөвлөлтийн дагуу барьж байгуулсан, олон нийтийн орон зайн, амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх газар, үйлчилгээний төвүүдтэй уялдсан байна;
  - 4.1.2. Сандал нь суухад тухтай, бат бөх, суух хэсэгт ашиглагдах материал нь дулаан, суудлын өндөр, түшлэг, гарын тавиур нь хүнд ээлтэйгээр хийгдсэн байх;
  - 4.1.3. Сандалыг байрлуулах нь нээлттэй орон зайн сүлжээгээр явган зорчигчийн хөдөлгөөний эрчмийг дэмжих явдал бөгөөд үзэгдэх орчин сайтай, нам гүм болон чимээ шуугиан ихтэй газар суух сонголтуудыг бий болгосон байх;
  - 4.1.4. Металл хийцийн эд ангийг зэврэлтээс хамгаалах, модон хийцийн эдэлгээг уртасгах, ус чийгийг тусгаарлах зорилгоор стандарт шаардлага хангасан будаг, өнгөөр, технологийн дагуу будсан байх.
- 4.2. Нийтийн эзэмшлийн сандлын стандарт хэмжээг зураг 2 болон хүснэгт 2-т үзүүлэв.




Зураг 2. Нийтийн эзэмшлийн сандлын хэмжээ (Жишээ зураг)

## Хүснэгт 1. Нийтийн эзэмшлийн сандлын хэмжээ


Таних тэмдэг	Хэмжээний нэр	Хэмжээ /мм/
V	Суудлын өргөн	1800 – 2000
H	Суудлын өндөр	450 ( $\pm 20$ )
D	Суудлын үр ашигт гүн	450 – 500
h	Суудлаас дээших түшлэгийн дээд ирмэгийн өндөр	500 – 800
R <sub>1</sub>	Суудлын ирмэгийн матийсан радиус	20 – 50
R <sub>2</sub>	Түшлэгийн дээд ирмэгийн матийсан радиус	20 – 50
a	Суудлын налуугийн өнцөг	0 – 4 градус
b	Түшлэгийн налуугийн өнцөг	95 – 106 градус

## 5. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САНДЛЫН ТӨРӨЛ АНГИЛАЛ

5.1 Нийтийн эзэмшлийн сандлыг түшлэгтэй ба түшлэггүй гэж хоёр ангилаа.



Зураг 3. Түшлэгтэй сандал



Зураг 4. Түшлэггүй сандал


(Жишиг зураг)

5.2 Нийтийн эзэмшлийн сандлыг хийхэд ашигласан материалыас нь хамааруулж модон сандал, төмөр сандал, чулуун сандал гэж ангилаа.

Зураг 5. Модон сандал	Зураг 6. Төмөр сандал	Зураг 7. Чулуун сандал
(Жишиг зураг)		

## 6. САНДЛЫГ БАЙРЛУУЛАХ


- 6.1. Сандлыг тууш үргэлжилсэн явган замын 50-100 метр тутамд байрлуулна.
- 6.2 Суухад тохиромжгүй газруудыг хориглох архитектурын хийц ашиглан хязгаарлалт хийж болно. Хориглох архитектурын хийц нь тухайн газарт суух боломжгүй нөхцөлийг архитектур дизайны элемент ашиглан бүрдүүлж байх ёстой.



Зураг 8. Явган зам дагуу сандал байрлуулах (Жишээ зураг)




Зураг 9. Цэцэрлэгт хүрээлэн, амрах талбайд сандал байрлуулах загвар (Жишээ зураг)




Зураг 10. Цэцэрлэгт хүрээлэн, амрах талбайд сандал байрлуулах загвар (Жишээ зураг)

## 7. САНДЛЫГ СУУРИЛУУЛАХ

- 7.1 Сандалыг газарт хөдөлгөөнгүй бэхэлж суурилуулах бөгөөд тэлэгч боолт ашиглаж газрын гадаргад бэхэлнэ.
- 7.2 Чулуун сандлыг бэхэлгээгүй байрлуулж болно.
- 7.3 Сандалыг суурилуулах сууринийн хэсэглэлийг Зураг 11, 12 -т үзүүлэв.



Зураг 11. Сандал суурилуулах /хөлийг газарт боож суурилуулах/ (Жишээ зураг)



Зураг 12. Хэсэглэл-2 (Жишээ зураг)

## 8. САНДЛЫН МАТЕРИАЛД ТАВИХ ШААРДЛАГА

- 8.1. Монгол орны цаг уурын эрс тэс нөхцөл байдалд нийтийн эзэмшлийн зам талбай цэцэрлэгт хүрээлэнд байрлуулах сандлын суудлыг модон материалаар хийх нь нэн тохиромжтой бөгөөд хүйтний улиралд хайрахгүй жиндүүлэхгүй байх нь чухал юм.
- 8.2. Доорх хүснэгтэд сандлын суудал хийх материалын тохиромжтой байдлыг үзүүлэв.


Хүснэгт 2. Сандлын суудал хийх материалын тохиромжтой байдал.

Үзүүлэлт	Үндсэн материалын төрөл			
	Мод	Чулуу	Хуванцар	Металл
Тухтай байдал				
Температурын өөрчлөлтөд дулаан, хүйтнийг дамжуулахгүй байх шинж чанар				
Будах шаардлагатай				
Цэвэрлэгээний шаардлага				
Хүйтэн цаг уурт хайрахгүй, жиндүүлэхгүй байх шинж чанар				

Тохиромжтой      Тохиромж багатай      Тохиромжгүй

## 9. САНДЛЫН ӨНГӨ

*Хүснэгт 3. Сандалын эдлэхүүний өнгөний төрөл*


№	Нэр, тэмдэглэгээ	Өнгө	Өнгөний код
<b>A. Металл</b>			
1	Мөнгөлөг RAL9006		C - 0 M - 0 Y - 0 K - 20
2	Цайвар саарал RAL7046		C - 0 M - 0 Y - 0 K - 10
3	Саарал RAL9001		C - 0 M - 0 Y - 0 K - 40
4	Цагаан RAL9003		C - 0 M - 0 Y - 0 K - 0
<b>Б. Мод</b>			
1	Модны өөрийн өнгө		(Жишээ зураг)
2	Улаан хүрэн		(Жишээ зураг)
3	Бор шар		(Жишээ зураг)

Хотын стандарт —

4	Хүрэн бор	 <i>(Жишээ зураг)</i>
---	-----------	--

## 10. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САНДЛЫН ЖИШИГ ЗАГВАР

10.1. Сандалын загвар №UCS PB01 (Жишээ зураг)






10.2. Сандалын загвар №UCS PB02 (Жишээ зураг)



Хотын стандарт




10.3. Саналын загвар №UCS PB03 (Жишээ зураг)







10.4. Саналын загвар №UCS PB04




10.5. Саналын загвар №UCS PB05 (Жишээ зураг)



10.6 Саналын загвар №UCS PB06 (Жишээ зураг)





## 11. ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

11.1. Нийтийн эзэмшилийн сандал бохирдол, элэгдэл, эвдрэлээс шалтгаалан иргэдэд осол гэмтэл учруулах болзошгүй нөхцөл байдлыг үнэлж байнгын хяналт, үнэлгээ хийж цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.

*Хүснэгт 4. Сандалын ашиглалтын байдалд хяналт үнэлгээ хийх чиглэл*

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Бохирдолтой эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Сандлын гадаргын бүрэн бүтэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Бэхэлгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан, гээгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Шавж хорхойд идэгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Модон эдлэхүүний хугарсан гэмтсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Ялзрал, зэврэлттэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

**Тайлбар:** Нийтийн эзэмшилийн сандал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

## НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САНДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ







Нийтийн эзэмшлийн сандалд тавигдаж байгаа материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг сандлыг хүлээн авах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 1.) -ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

*Хүснэгт 5. Саналыг хүлээн авах шалгуур үзүүлэлт*

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Сандлыг зөв байрлалд, зөв харуулж байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Сандлыг стандартын дагуу суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Нийтийн эзэмшлийн сандлын хэмжээний стандартад нийцэж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Сандал даацын стандартад нийцэж байгаа эсэх /Сандал 113.4 кг хөндлөн үйлчлэлийн ачааг дааж байх ёстой/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Суудал болон түшлэг модон материалаар хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Сандлын модон хийц хэсгүүдэд байгалийн болон механик нөлөөллөөс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Сандлын металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн аль эсхүл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Чулуун хийц хэсгүүд стандартын шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Суудлын өндөр, түшлэг, гарын тавиур нь хүнд ээлтэйгээр хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Загвар нь өгөгдсөн стандарт загваруудтай тохирч байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Тухайн хэсэгт ашиглагдаж байгаа бусад сандлын нэгэн төрөл, жигд байдал хангагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

**Тайлбар:** Хотын нийтийн эзэмшлийн сандал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

**ХАВСРАЛТ 1.****Сандлын металл хийцлэлийн материалын төрөл, үзүүлэлт**

№	Материалын нэр	Төрөл, марк	Зузааны хэмжээ	Огтлолын хэмжээ, мм	Ханын зузааны хэмжээ, мм	Хүндийн хэмжээ, м/кг
1	Дөрвөлжин металл хийц (квадрат)	 (Жишээ зураг)		A=30x30	S=1.5-2.0	1.07-1.39
2	Дөрвөлжин металл хийц (квадрат)	 (Жишээ зураг)		A=50x50	S=1.5-2.5	0.64-1.5
3	Тэгш өнцөгт металл хийц	 (Жишээ зураг)		A=40x25	S=1.5-2.5	0.64-1.5
4	Тэгш өнцөгт металл хийц	 (Жишээ зураг)		A=60x30	S=1.5-2.5	1.07-2
5	Зууван металл хийц	 (Жишээ зураг)		A=45x28 A=38x25	S=1.5-2.5	1.32-1.73
6	Цилиндр цул төмөр хийц	 (Жишээ зураг)		D=50		1.13-3.5

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Сурагчийн ширээ ба сандал, Техникийн шаардлага MNS6582 : 2016
- Public Seating, Smithsonian Institution Accessibility Guidelines
- Have a seat: movable chairs or benches?, <https://www.pps.org/article/movable-seating>
- Secrets of good benches and seating in public space, Published on Nov 26, 2018, <https://issuu.com/stipoteam/docs/benches>





Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам  
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



[www.standard.ub.gov.mn](http://www.standard.ub.gov.mn)



Хотын стандарт, хяналтын газар